


ХУУЧИН БҮРТГЭЛТЭЙ ХЭРЭГЛЭГЧИД ШИНЭЧЛЭГДСЭН “СМАРТ ОФФИС 2.0” СИСТЕМД НЭВТРЭХ ЗААВАР


Хуучин бүртгэлтэй хэрэглэгчид шинэчлэгдсэн “Смарт оффис 2.0” системд нэвтрэхдээ дараах 2 байдлаар нэвтэрч орно.

- **Нууц үг сэргээх үйлдэлээр нэвтэрч орох**



1. Нэвтрэх хуудаснаас “Нууц үг сэргээх” товчийг дарна.
2. Тоон гарын үсэг дээр бүртгэлтэй мэйл хаягаа оруулан “Илгээх” товчийг дарна.
3. Мэйл хаягаар нууц үг сэргээх мэйлийг амжилттай илгээсэн цонх харуулна.
4. Мэйл хаягаа шалгаад ирсэн мэйлийн “Нууц үг сэргээх” товчийг дарна.
5. Нууц үг сэргээх цонхонд шинэ нууц үгээ оруулан “Сэргээх” товчийг дарснаар нууц үг амжилттай үүсэн системд нэвтэрч орно.

- **Тоон гарын үсгээр нэвтрэх үйлдлээр нэвтэрч орох**



1. Нэвтрэх хуудаснаас **“Тоон гарын үсгээр нэвтрэх”** товчийг дарна.
2. Компьютерт залгасан байгаа токен төхөөрөмжийн мэдээллийг харуулсан цонх гарч ирэх ба нэвтэрч орох тоон гарын үсгээ сонгон **“Сонгох”** товчийг дарна.
3. Токен төхөөрөмжийн нууц үгийг оруулан **“Нэвтрэх”** товчийг дарснаар системд нэвтрэн орно.